

Хоёрдахь үхэл болох Галт нуур



Тамыг галтай нуур шиг төсөөлөх нь түгээмэл учраас “галт нуур” там мөн гэмээр. Библи энэ талаар юу гэж заадгийг авч үзье. “Галт нуур” гэсэн нэр томъёо зөвхөн «Илчлэл» номд гардаг бөгөөд тэр номд таван удаа дурдагдана.

Тухайлбал:

--“Өнөөх араатан болон хуурамч эш үзүүлэгч хамтдаа баригдав. (...) Тэр хоёрыг шатаж буй хүхэртэй галт нуурт амьдаар нь хаяв” (19:20).

--“Тэднийг мэхэлсэн диавол хүхэр бүхий галт нуурт хаягдлаа. Тэнд мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байх агаад тэд үеийн үед өдөр шөнөгүй тарчилна...” (20:10)



Энэ хоёр эхний ишлэл хүний тухай биш. Галт нууранд амьдаар нь хаягдаж “үеийн үед” тарчлах “улсууд” бол араатан, хуурамч эш үзүүлэгч, адгийн муу ёрын сүнс гурав. Энэ бол Есүсийн дурдсан “диабол болоод түүний элч нарт бэлтгэсэн мөнх гал” билээ (Матай 25:41). Галт нуур бол Сатан ба тэрсэлсэн тэнгэрэлчид зориулсан шийтгэл гэж ойлгогдож байна.

Дараа нь галт нуур “цагаан сэнтийн шүүх”-ийн тухай Иоханы үзсэн үзэгдэлд дахин гарч ирдэг. Энэ шүүхийг “эцсийн шүүлт” гэж нэрлэх нь түгээмэл. “Өөрийнхөө томилсон нэгэн Хүнээр дамжуулж ертөнцийг шударгаар шүүх өдрөө” Бүтээгч Эзэн тогтоосон нь энэ (Үйлс 17:31).

Тухайлбал: **“Цагаан өнгөтэй агуу сэнтий болон дээр нь Залрагчийг би харав. Түүний дүр төрхөөс газар, тэнгэр зугтсан бөгөөд тэдэнд байх газар эс олдов. Их бага**

үхэгсдийг сэнтийн өмнө зогсохыг би харлаа...”
(Илчлэл 20:11-12)





Тэр сэнтий дээр Залрагч бол Бүтээгч Эзэний “үхэгсдээс амилуулсан” Есүс Христ юм (Үйлс 17:31). Харин сэнтийнх нь өмнө ямар хүмүүс зогсож байгаа гэвэл, “анхны амилалт”-анд багтаагүй “үлдсэн” хүмүүс (Илчлэл 20:5).

Их Эзэн Есүс Христийн Аавыг таньдаг хүний хувьд “бүх юмсыг Өөртэйгээ эвлэрүүлэх” төлөвлөгөөг нь мэдээгүй цагт тус шүүх ойлгомжгүй (Холоссай 1:20). Муу хүмүүсийг дахин амилуулахад шаардлагатай тэр агуу их хүч зарцуулах хэрэг юу вэ? Эсвэл тэд (олон хүний төсөөлснөөр) аль хэдийнэ тамд зовж байгаа бол тэрнээс гаргаж давхар шийтгэл оноох нь ямар ашигтай вэ? Энэ шүүхээр Их Эзэн Өшөө авагч гэсэн нэр л авах юм бол тэднийг дахин амь оруулж яах нь вэ?

Үхэгсэд ямартай ч шүүх өдөр хүртэл тамд тамлагдаагүйг Иоханы үгнээс ойлгомжтой. Тэд “мянган жилийг дуустал амилсангүй [грек: амьдраагүй]” учраас тэр (Илчлэл 20:5). Энэ тайлбар нь үхсэн байдлыг амьд байхын эсрэг гэсэн жирийн ойлголтыг маань баталдаг. Үхэгсэд юу ч мэдэхгүй учраас тамлуулахыг ч мэдэхгүй (Номлогч 9:5). “Анхны амилалт”-анд багтаагүй хүмүүс бол Иохан 3:16-гийн хэллэгээр “Хүүд итгээгүй мөхсөн”. Хачирхалтай нь, “мөхөх” гэдэг үг «Илчлэл» номд нэг ч гардаггүй.



Мянган жилийн жаргал дуусахаар эдгээр “мөхөгсөд” амилна гэж саяны ишлэлээс ойлгогдож байна. “Анхны амилалт”-ыг Есүс мөн “амийн амилалт” гэж нэрлээд энэхүү амилалтыг “ялын амилалт” [грек: шүүхийн амилалт] гэж тодорхойлсон юм (Иохан 5:29). Тэд цагаан өнгөтэй агуу их сэнтийд суусан Түүнд шүүгдэх учраас тэр (Илчлэл 20:11; Үйлс 17:31).

Тэр л шүүхээр Ионагийн үеийн “Ниневегийн хүмүүс босож [=дахин амилж]”, мөн Соломон хаантай уулзахаар ирсэн “өмнөдийн хатан хаан босож [грек: сэжж]” Есүсийн итгэлгүй үеийнхэнтэй хамт шүүгдэх болно (Матай 12:41-42).



“Номууд дэлгээстэй байв. Өөр нэг ном дэлгээстэй байсан нь амийн ном аж.



Үхэгсэд¹ үйлсийнхээ дагуу эдгээр номуудад бичигдсэнээр шүүгдэв... Тэгээд үхэл ба Үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой. Мөн амийн номын бичвэрээс нэр нь олдоогүй бүхэн галт нуурт хаягдав.” (20:12-15)

–“...хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхайрагчид, мэргэчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалчуудад ногдох хувь нь хоёр дахь үхэл буюу гал, хүхрээр шатаж буй нуур юм” (21:8).


Үүнээс ойлгож авах гол хэдэн зүйл бол энэ:

→ Энэ шүүх шударгаар явагдана (цагаан өнгө шударгыг бэлэгдэнэ). Шүүгч дураараа шүүхгүй, олон номд нарийвчлан тэмдэглэсэн үйлс бүрт тохирсон хариу өгнө.

1 Тэднийг мянган жилийн өмнө “анхны амилалт”-аар амилсан итгэгч хүмүүсээс ялгаж, нөгөө “үлдсэн үхэгсэд” мөн болохыг тодорхойлохын тулд “үхэгсэд” гэж нэрлэсэн хэвээр. Энэ бол “**хадгалал**” гэж нэрлэж болох хэлний дүрслэх арга. Үүний жишээд бид “машин унах” тухай ярьдаг. Явж буй машиныг хяналттай залж явуулахыг илэрхийлсэн оновчтой үг бидэнд байхгүйн улмаас машин байгаагүй цаг үед морь мордоход хэрэглэдэг байсан тэр л үгийг бид хадгалж ирсэн. “Жолоо” гэдэг үг мөн адил малын аж ахуйгаас л гаралтай үг. Ийм маягаар шинэ нөхцөл байдалд ч гэсэн хуучин нэр томъёогоо хадгалж хэрэглэх нь түгээмэл. Ийм л утгаар “суунги нь алхаж, дүлий нь сонсож” (Матай 11:5), “үхсэн хүн босоод ярьж эхлэв” (Лук 7:15). Тэд дүлий хэвээр ч гэсэн сонсдог болсон зэрэг утгагүй зүйлийг хэлээгүй нь мэдээж. Энэ хүмүүс алхаж, сонсож, босохоосоо өмнө суунги, дүлий, үхсэн тэр л хүмүүс болохыг цөөн үгээр илэрхийлэхэд хадгалал хэмээх дүрслэх хэрэглүүрийг ашигласан.



Учир нь, “Бурхан хүн бүрд үйлсийнх нь дагуу хариу өгнө. Тэвчээртэйгээр сайныг үйлдэж, алдар, хүндэтгэл болон мөхөшгүй байдлыг хайгчдад мөнх амь өгнө. Харин хувиа хичээгч, үнэнийг дагадаггүй мөртлөө зүй бусаар дагадаг хүмүүст уур хилэн ба хилэгнэл буулгана. Муу муухайг үйлдэгч хүн бүр дээр цөхрөл, зовлон байх болно... Харин сайныг үйлдэгч хүн бүрд алдар, хүндэтгэл ба амар тайван байх болно... Учир нь, ялгаварлах үзэл Бурханд байдаггүй.” (Ром 2:6-11).



Ямартай ч Ионагийн үеийн Ниневечүүд Ертөнцийн Эзэний тунхаглуулсан үгэнд итгээд гэмшиж байсныг Есүс сайшаасан. Бас Шеба орны хатан хаан цэцэн мэргэн ухааныг алс холоос эрж хайсныг Есүс үнэлсэн билээ (Иона 3:5; Матай 12:41-42).



➔ Хүн галт нууранд хаягдах тухай дээрх хэсэгт тэр нуурыг “хоёр дахь үхэл” болохыг тайлбарласан. Энэ тайлбарыг хоёр давтсан. Их Эзэний өгсөн тайлбарыг бид тайлбарлах хэрэггүй. Үүнээс дүгнэхэд тийш хаягдах муу үйлстэй хүмүүс дахин үхэх ял авах болно. Гэтэл тэд галд тарчлах тухай нэг ч үг алга.

➔ Дээр нь үхэл ба Үхэгсдийн оронг тийш хаягдахыг хэлсэн нь сонирхол татна. Үхэл ба Үхэгсдийн орон хоёр шатааж болохоор бодит зүйл биш, хийсвэр ойлголт юм. Тэднийг галт нуур хаях нь шилжсэн утгатай гэсэн үг. Үхсэн хүн л “үхэл”-д баригддаг, нас барсан хүн л “Үхэгсдийн орон”-д нойрсдог. Үхэгсдийн орон

там биш болохыг бид энэ цувралын эхний нийтлэлээс олж харсан.

Тэгвэл “үхэл ба Үхэгсдийн орон хоёр галт нууранд хаягдсан” гэдэг нь үхлийн хүч, тийш орсон хүмүүст хязгаарлагдана гэсэн утгатай болж таарна.

Тиймээс ч үүний дараахан бүтээгдэх шинэ дэлхийд “үхэл байхгүй болно” гэжээ (Илчлэл 21:4).

“Галт нуур бол
хоёр дахь үхэл.”

--Бүтээгч нь

-- чухал зарчим --

Ертөнцийн Эзэний
тайлбарыг бид өөр утгаар
тайлбарлах ёсгүй,
байгаагаар нь
хүлээж авах ёстой.



→ Нэр нь “амийн ном”-д бичигдээгүй үхэгсэд цаазаар авахуулна (зөвхөн амьд хүн үхэж чадна гэж хэлэх нь илүүц биз ээ). Тэдний үйлс дэндүү муу байсан учраас тэр. Тэд шинэ газар дэлхийн гайхамшигт сайхныг үзэхгүй.



“Ямар ч бузар юм болон жигшүүрт зүйл үйлддэг болон худал ярьдаг хэн ч хэзээ ч тийшээ орохгүй. Харин зөвхөн Хурганы амийн номд нэрс нь бичигдсэн хүмүүс л орох ажгуу.” (Илчлэл 21:27)

Нэрс нь “амийн” номд бичсэн хүмүүс шүүх дээр илт дурдагдаагүй ч тийм хүн үхэх ял авахгүй, шинэ дэлхий дээр амьдрах эрх авна.

“Хоёрдахь үхэл” гэсэн хэллэгийн хувьд дахин хэлэхэд, бид Их Эзэний өгсөн тайлбар дээр дахиад утгын тайлал гаргах ёсгүй. Библид гардаг “хоёр дахь” зүйл нь “эхний зүйл”-ийг цаг хугацааны эрхээр дагадаг болохоос үндсээрээ огт өөр мөн чанартай болж хувирдаггүй. Жишээлбэл, аавынхаа үгийг дагасан хоёр дахь хүү бол үгийг нь дагаагүй нэг дэх хүү шиг л хүү (Матай 21:30), бүтээлийн түүхийн хоёр дахь өдөр бол нэгдэх өдрийн адилаар өдөр мөн.



Хоёрдугаар Адам болох Есүс эхний Адамын адил хүн (1 Коринт 15:47).² Үүнчлэн хоёр дахь үхэл бол эхний үхлээс ялгаагүй үхэл буюу ухаангүй, үл орших байдлыг хэлнэ (үхлийн тухай судалгааны цувралыг үзнэ үү).

Ялын дээд хэмжээ оноох гэмт хэрэг

Ялын дээд хэмжээ авч, хоёрдахь удаагаа үхэхэд хүргэх гэмт хэргийг дараа нь тооцсон байна (Илчлэл 21:8, бас 21:27, 22:15-г үзнэ үү).

- Юун түрүүнд “хулчгар” ба “итгэлгүй” байхыг дурдсан. Итгэлгүй хүмүүсийн жишээд Есүсийн үеийнхнийг дурдаж болно. Дэлхийг шүүх өдөр Тир, Сидон мөн Содом хотынхон хүртэл Есүсийн гайхамшигийг хараагүйгээс болж Өөрийнх нь итгэлгүй үеийнхнээс хөнгөн шийтгэл авах болно гэж Есүс хэлсэн (Матай 11:21-24).
- Дүүгээ алсан Каин мэт хүмүүс “алуурчид”-ын тоонд орох нь ойлгомжтой (1 Иохан 3:12).
- “Жигшүүрт” ба “завхайрагч” хүмүүсийн ёс бус үйлсийн тодорхойлолт Левит 18-д бий. Эдгээрт хүүхдээ харийн бурханд тахин шатаах, тэдгээр

2 Өөр олон жишээ бий. Петрийн хоёрдугаар захидал бол уран сайхны ном юмуу видео бичлэг биш, эхний захидал шиг л захиа (2 Петр 3:1). Есүсийн хийсэн хоёрдахь гайхамшиг нь эхний гайхамшгаас ялгаагүй гайхамшигтай (Иохан 4:54). Хоёр дахь харуул (Үйлс 12:10), хоёрдахь хөшиг (Еврей 9:3), хоёр дахь амьтан (Илчлэлт 4:7), хоёр дахь гай тотгор (Илчлэл 11:4), хоёр дахь суурь (Илчлэлт 21:19) – эдгээрийн утгыг тайлах шаардлага байхгүй, бүгд эхнийхтэй адилхан зүйлс.



хуурамч бурхны таалалд нийцэх гэж төрөл бүрийн садар самуунд оролцох зэрэг жигшүүрт хэрэг багтна.



• “Мэргэчид”
[грек: фармакос, G5333] гэж орчуулсан үгийг «Хуучин гэрээ»-нээс хөөвөл “мэргэлэх” биш, “хараал жатгах” буюу “бусдад гайдуудсан уншлага, хар

домын зан үйл хийх”-ийг хэлнэ (Гэтлэл 7:11, Дэд хууль 18:10, СМО).

Орчин үеийн “фарм” (буюу “эм”) адилхан үгийн үндэстэй болохоор хүнийг хохироож алдаг эм тариа найруулах үйлийг ч хэлсэн болж таарна.



Ф А Р М
С И Н Т Е З

• “Шүтээнд мөргөгчид” Бүтээгч Эзэнийг хүндлэхийн оронд муу ёрын сүнсэнд тахил өргөдөг (1 Коринт 10:20). Дээр нь бусдад хуурамчаар хандаж, үнэнийг уландаа гишгэдэг “бүх худалч” буюу “худлыг хайрладаг, үйлддэг бүхэн” дээд зэргийн ял авна (Илчлэл 22:15).



Паулын бичсэнээр “**ийм зүйлийг үйлдэгч нь үхвэл зохино гэсэн Бурханы зарлигийг тэд мэддэг хэрнээ өөрсдөө үйлдээд зогсохгүй, бусдыг үйлдэхэд нь ч сайшаадаг байна**” (Ром 1:32, Ром 1:18-с уншина уу).

Бүтээгч Эзэний Хуулийн дагуу цаазлагдсан байх тэр хүмүүс “гадна талд байх” нь (Илчлэл 22:15) тэднийг аймшигт үйлсийнхээ хамт шинэ дэлхийгээс цөллөгдөн үхэлд хоригдсон байхыг хэлнэ. Шийтгэлийнх нь хугацааг Библид мэдэгдээгүй юм.

Эдгээр үйлсийг авч үзэхээр бүгд тодорхой хэмжээгээр шашин шүтлэгтэй холбоотой нь бодуштай. “Хулчгар” гэж орчуулсан үг [грек: дейлос] “шашин” гэж орчуулах грек үгт ордог (Үйлс 25:19; грек: дейсидаймония). Энэ нь “бурхдаас айж балмагдах” гэсэн утгатай үг. Гэтэл Бүтээгч Эзэн “бидэнд айдсын [грек: дейлиа³] сүнсийг” өгөөгүй” билээ (2 Тимот 1:7).



3 “Айдас” гэдэг үг Библид олон гардаг ч, энд “айдас” гэж орчуулсан тусгай грек үг Библийн өөр хаана ч гардаггүй. “Хулчгар” ба “шашин” гэж орчуулсан адилхан үндэстэй хоёр үг мөн адил нэг нэг гардаг.



Юу гэвэл, Их Эзэн бидэнд өгсөн сүнс биднийг балмагдуулж хулчгар болоход хүргэдэггүй!

Бусад гэмт хэрэг шашинтай илт холбогдоно. Израйльчууд худалч бурхдын араас явж, Бүтээгч Эзэний уур хилэнг өдөөсөн тухай Мосе бичсэн.

“Харь газрын жигшүүрт бузар юмсаар Харамнах сэтгэлийг нь хөдөлгөж, уур хилэнг нь өдөөв. Өргөл тахилаа тэд Бурханд биш чөтгөрүүдэд өргөв...” гэв (Дэд хууль 32:16-17, СМО).



Шашин ба гэмт хэрэгтний холбоо мөн эцсийн үеийн хүмүүсийн тухай дараах ишлэлээс харагдана. Тэд “чөтгөрүүдэд болон харж, сонсож, явж чаддаггүй алтан, мөнгөн, гуулин, чулуун, модон шүтээнүүдэд мөргөхөө больсонгүй.

Тэд хүн алсандаа ч, ид шидэндээ ч, завхайрсандаа ч, хулгай хийсэндээ ч гэмшсэнгүй.” (Илчлэл 9:20-21)



“Хоёрдахь үхэл Их Эзэнээс үүрд мөнх салахыг хэлнэ” гэсэн тайлбар

Галт нуурыг Их Эзэний Үг нэгэнт “хоёрдахь үхэл” гэж тайлбарласан байхад теологичид даанч утгыг нь өөрөөр гаргах нь түгээмэл. Тухайлбал: “Эхний үхэл бие махбодынх, хоёр дахь үхэл сүнснийх буюу Их Эзэнээс үүрд мөнх салахыг хэлнэ...” Ингээд “үхэл” гэсэн үгийн утгыг дураараа өөрчилдөг. Ийм төрлийн “сүнслэгжүүлсэн” тайлбар Их Эзэний бичүүлсэн тайлбарыг үгүйсгэдэг! Үүгээр зогсохгүй, үхлийн тухай өөр олон ишлэлтэй зөрдөг учраас буруу болж таарна.⁴

4 Үхэл чухам юу болохыг ойлгосон хүнд энэхүү “тайлбарын тайлбар” буруу болох нь ил. Үхлийг ингэж “сүнслэгжүүлэн тайлбарлах” нь дахин төрөх тухай Есүсийн үгийг буруу ойлгосноос үүдэлтэй. Үүнд: “Та нар дээрээс төрөх ёстой” гэж хэлснийг нь (Иохан 3:7) тэд “Есүс биднийг сүнсний хувьд дахин төрөх хэрэгтэй” гэж гуйвуулан тайлбарладаг. Тэгээд “эхний төрөлт бие махбодийнх, хоёр дахь төрөлт сүнснийх. Үүнчлэн эхний үхэл бие махбодийнх, харин хоёр дахь үхэл сүнснийх” гэсэн дүгнэлтэнд хүрдэг. Энэ бодлыг цааш нь хөөвөл хичнээн буруу болох нь тод харагдана. Тухайлбал: Хоёр дахь удаагаа (буюу сүнсээрээ) төрөөгүй хүн яаж хоёр дахь удаагаа (буюу сүнсээрээ) үхэх вэ? гэдэг асуудал тавигдана.

Гэтэл Библид хоёр дахь зүйлс олон байсан ч “хоёр дахь төрөлт” хаана ч байхгүй. Есүсийн дахин төрөх тухай үг хувь хүн ээжээсээ төрөхийг хэлээгүй, харин Израиль ард түмнээрээ шинээр буй болох зөгнөлд хамаатай (Иохан 3:4-5; Исаиа 66:8). Есүсийг ирэхээс өмнөхөн Израйль тэрхүү “төрөлтийн өвдөл” болох зовлонгийн үеэрээ дамжин явж, ариусгагдах учиртай (Матай 24:8,21; Малахи 3:2-3). Тэгээд Израйлийн ард түмэн нэг л өдрийн дотор дээрээс “төрж” шинэ зүрх, шинэ сүснтэй болно. Мянган жилийн Хаант улсын эхээр болох энэ явдалд мянган жилийн дараах шүүхээр оногдох “хоёр дахь үхэл” огт хамаагүй.



Тэгсэн ч гэсэн “Там бол Ертөнцийн Эзэнээс буюу сайн сайхнаас үүрд мөнх сална” гэж тайлбарладаг хүн их бий. “Там бол Ертөнцийн Эзэний байхгүй цорын ганц газар” гэдэг. Гэтэл тийм санаатай ишлэл Библийн хаанаас ч олохгүй.

Энэ теологичдод Их Эзэн хандан: **“Миний олж харахгүй тийм газарт хүн нуугдаж чадах уу? хэмээн Мөнхийн Эзэн асууж байна. Газар,**

тэнгэрийн хаа сайгүй би оршин байдаг бус уу? хэмээн Мөнхийн Эзэн асууж байна.”

(Иеремиа 23:24, ББ)

Учир нь, **“Сайн муу гэлтгүй бүхнийг ажиж, хаа сайгүй ИАВЭгийн мэлмий тольдоно.”**

(Сургаалт үгс 15:3, СМО)



Тиймээс ч **“Таны Сүнснээс би хаашаа холдох билээ? Таны өмнөөс би хаашаа бултах билээ? ... Доош Үхэгсдийн оронд хэвтрээ заслаа ч Та тэнд”** (Дуулал 139:7-8, СМО).

Үхэгсэд хаана байна, тэнд Их Эзэн ч байдгийг энэ ишлэлд маш тодорхой хэлсэн байна. Үхлээр ч гэсэн хүн Их Эзэнээс зугтан салах ямар ч боломжгүй нь лавтай.



Тэртэй тэргүй Ертөнцийг бүтээгч Эзэнгүйгээр хэн ч, юу ч оршин тогтнох боломжгүй – **“Бид Түүний дотор амьдарч, хөдөлж, оршин тогтодог”** (Үйлс 17:28) гэж Паул Есүсийн тухай юу ч мэдэхгүй Афин хотынхонд хэлсэн. Мөн, **“Бүх юмс Түүний дотор оршин тогтнодог”** (Колоссай 1:17) гэдэг нь жам. “Бүх юмс”-ад Үхэгсдийн орон ба дотор нь нойрсож буй үхэгсэд хүртэл гарцаагүй багтана. Хэрэв там байдаг байсан бол тамын гал дөл хүртэл Түүний хүчээр л бадарч чадахсан. Юм бүхнийг бүтээгээд зогсоогүй эгнэгт оршин тогтноулагч Их Эзэнээс сална гэж байхгүй билээ.

Дүгнэлт: Хоёрдахь үхэл бол цаазын шийтгэл
“Үхэгсэд амьдрахгүй” гэсэн Иоханы үг, мөн “галт нуур бол хоёрдахь үхэл” гэсэн Ертөнцийн Эзэний өгсөн тайлбарыг байгаагаар нь хүлээж авбал тодорхой ойлголт гарна. Үүнд: Эцсийн шүүхээр амь орж шүүгдэх аймшигт үйлстэй хүмүүс дахин үхэх дээд хэмжээний ял шийтгэл авна. Тэд “хүхрээр шатах галт нууранд хаягдах” аргаар цаазлагдаж шууд үхэх юм байна.⁵

5 Шүүхийн амилалтаар хэн ч үхэшгүй амьдрал хүртэхгүй бөгөөд иймд дахин үхэх боломжтой. Үхэх ял авахгүй хүмүүс шинэ дэлхийд амьдрах болно. Тэнд үхэл байхгүй ч хүмүүс амийн модны жимснээс идээд амиа тэтгэх болно (Илчлэл 22:14).



Галт нуур тэдний шинэ булш болж тэд нэг ёсондоо “хадан гэр”-ээ “галан гэр”-ээр солих болно. Хэдэн мянган жилийн турш үхэлд баригдахыг нь Библид мэдэгдээгүй юм. Үхэл бол амьгүй байх, юу ч мэдэхгүй, юу ч мэдрэхгүй байх байдал юм (Номлогчийн үгс 9:10). Иймд хоёр дахь удаагаа нас барсан хүмүүс галт нууранд тарчлахгүй, харин тэнд хязгаарлагдсан Үхэгсдийн оронд “нойрсдог” мэт ухаангүй байж, үхэл бүрмөсөн халагдах үеийг нэг ёсондоо хүлээх болно.

Учир нь, “Эцэст нь устгагдах [грек: хүчингүй болгох] дайсан бол үхэл мөн” хэмээн Паул зөгнөсөн (1 Коринт 15:26).

Галт нууранд хязгаарлагдсан үхэл бүрмөсөн хүчингүй болсон байхад зөвхөн амьдрал үлдэх боломжтой. Тэр л үед “Адам дотор БҮГД үхдэгчлэн Христ дотор БҮГД амьд болгогдох болно” гэсэн үг бүрэн биелнэ (1 Коринт 15:22; “амьд болгогдох” гэсэн нь үхэшгүй амь авахыг хэлнэ).



Энэ бүхнээс дүгнэхэд галт нуур үнэхээрийн муу хэрэг хийсэн хүнд оногдож болох дээд



Хоёрдахь үхэл болох Галт нуур □ 17

хэмжээний ял шийтгэл мөн боловч мөнхийн зовлонт там биш. Галт нуур, там хоёрын аль алинд гал дүрэлзэх боловч бусад бүх шинж чанараараа өөр.

Монголчуудын төсөөлдөг шиг “там” Библиэс хайгаад хайгаад олдохгүй. Харин олоод ойлгосон зүйл гэвэл, Их Эзэн маань алдсан бүхнээ заавал эрж хайдаг. Эрж хайснаа Тэр заавал олох болно.

Үхэл Түүнд саад болохгүй, үхэгсдийг Тэрээр амилуулж шүүхээр дамжин үнэнийг ухаарахад тусална. Үхэл бол Түүнд үйлчлэх зарц бөгөөд тогтоосон цагтаа Тэрээр үхлийг халаад хүчингүй болгоно.

Их Эзэний маань төлөвлөгөө бодсоноос хамаагүй том юм байна.

Түүний төлөвлөгөө хэрэгжихгүй гэж үү?



Хэрэгжилгүй яах вэ! **“Зорилго минь биелнэ. Хүссэн бүхнээ Би хэрэгжүүлнэ”** гэж Их Эзэн Өөрөө хэлсэн (Исаиа 46:10).

Бүхнээс хүчит, хамгаас мэргэн Түүнийг магтъя!



Дараагийн нийтлэлд “там” гэсэн ойлголт хаанаас гарч ирсэнийг авч үзэх болно.

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Орчуулга тодруулаагүй тохиолдолд АБ-с авсан гэсэн үг.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org